



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 69

Өлгий


Орон нутгийн өмчийн концессын
зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай

Концессын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХҮИ хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан концессын зүйлийг тухайн жилийн төсвийн нөөц боломжтой уялдуулан хууль, журмын дагуу хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Х.Дармен/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЛАЗАТХАН



КОНЦЕССЫН ЖАГСААЛТАД НЭМЖ ОРУУЛАХ АЖЛУУД

<i>д/д</i>	<i>Салбар</i>	<i>Төсөл, арга хэмжээ</i>	<i>Эх үүсвэр</i>	<i>Тайлбар</i>
1	Боловсролын салбарт	Хөгжимт драмын театрын барилгын их засвар	ОНХСан	Тусгай зураг төсвөөр
2	Эрүүл мэндийн салбарт	Асрамжийн газрын барилга	ОНХСан	Тусгай зураг төсвөөр
3	Дэд бүтцийн салбарт	Сумдын төвийг нэгдсэн халаалтад холбох	ОНХСан	Тусгай зураг төсвөөр
		Өлгий хотын цэвэрлэх байгууламжийн сэргээн засалт	Улсын хөрөнгө оруулалт	Тусгай зураг төсвөөр
5	Хөдөө аж ахуй салбарт	Алтанцөгц сумын Цонжийн хөдөөгийн 500 га-ийн услалтын системийг үргэлжлүүлэн барих	Улсын хөрөнгө оруулалт болон хувийн хөрөнгө оруулалтаар	Тусгай зураг төсвөөр